



I-III/2022


Тархаасан: 2022 оны 5 дугаар сарын 12



Төлбөрийн тэнцэл 2022 оны 3 дугаар сард 382.2 сая америк долларын алдагдалтай гарчээ

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2022 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 972.4 сая америк долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх оны мөн үеэс 648.7 (3.0 дахин) сая америк доллароор өсжээ. Уг өсөлтөд барааны худалдааны алдагдал өмнөх оны мөн үеэс 483.8 сая америк доллароор, анхдагч орлогын алдагдал 169.9 сая америк доллароор өссөн нь голлон нөлөөлсөн байна. Мөн урсгал дансны алдагдал 2022 оны 3 дугаар сард 400.1 сая америк доллар болж, өмнөх сараас 230.6 сая америк доллароор өсжээ.

ЗУРАГ 1. УРСГАЛ ДАНС, сая америк доллароор, сараар



Үйлчилгээний худалдааны орлого 2022 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 179.7 сая америк доллар, зарлага 558.7 сая америк доллар болж, орлого өмнөх оны мөн үеэс 9.0 сая америк доллароор, зарлага 49.9 сая америк доллароор тус тус буурсан байна. Үйлчилгээний худалдааны алдагдал 2022 оны эхний улиралд 379.0 сая америк доллар болж, өмнөх оны мөн үеэс 40.9 сая америк доллароор буурчээ.

ХҮСНЭГТ 1. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, салбараар, сая америк доллароор

Үзүүлэлт	2021		2022*	
	III	I-III	III	I-III
Үйлчилгээ	- 111.5	- 419.9	- 80.8	- 379.0
Кредит	74.3	188.7	81.2	179.7
Дебит	185.8	608.6	162.0	558.7
Тээвэр	- 20.7	- 61.9	9.1	- 9.0
Кредит	51.0	129.0	57.4	120.8
Дебит	71.7	190.9	48.3	129.8
Аялал	- 51.9	- 244.1	- 39.2	- 217.2
Кредит	1.6	3.4	4.1	8.1
Дебит	53.5	247.5	43.3	225.2
Бусад үйлчилгээ	- 38.8	- 113.9	- 50.7	- 152.9
Кредит	21.7	56.3	19.7	50.9
Дебит	60.6	170.3	70.4	203.7

Хөрөнгийн данс 2022 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 27.2 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 2.8 сая америк доллароор өсжээ. Харин 2022 оны 3 дугаар сард 14.3 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 7.6 сая америк доллароор өссөн байна.

Санхүүгийн дансны тэнцэл 2022 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 236.1 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеэс 134.3 сая америк доллароор буурчээ. Харин 2022 оны 3 дугаар сард 126.5 сая америк долларын ашигтай гарч, өмнөх сараас 123.2 сая америк доллароор өссөн байна.

ХҮСНЭГТ 2. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, сая америк доллароор

Үзүүлэлт	2021*		2022*		Төлбөрийн тэнцэл 2021 оны эхний улиралд 170.4 сая америк долларын ашигтай байсан бол 2022 оны эхний улирлын урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум америк доллароор буурч, 953.6 сая америк долларын алдагдалтай болсон байна. Төлбөрийн тэнцэл 2022 оны 3 дугаар сард 382.2 сая америк долларын алдагдалтай гарч, алдагдал өмнөх сараас 151.8 сая америк доллароор өсжээ.
	III	I-III	III	I-III	
Урсгал данс	- 126.3	- 323.6	- 400.1	- 972.4	
Хөрөнгийн данс	11.3	24.4	14.3	27.2	
Санхүүгийн данс	- 244.9	- 370.4	- 126.5	- 236.1	
Алдаа болон орхигдуулга	33.5	99.3	- 122.9	- 244.5	
Нөөц хөрөнгө	163.4	170.4	- 382.2	- 953.6	

Ойлголт, тодорхойлолт

Төлбөрийн тэнцэл: Тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалын орлого, зарлагын гүйлгээг нэгтгэсэн статистикийн тайлан бөгөөд дараах 3 бүлгээр нэгтгэн боловсруулдаг.

Урсгал данс: Эдийн засгийн харьяат болон харьяат бусын хоорондох бараа, үйлчилгээ, анхдагч орлого, орлогын дахин хуваарилалтын урсгалыг харуулах бөгөөд бараа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлгийн нийлбэрээс бүрдэнэ.

Хөрөнгийн данс: Хөрөнгийн шилжүүлэг болон үйлдвэрлэгддэггүй, санхүүгийн бус активын шилжүүлэг гэсэн хоёр ангиллаар бүртгэнэ.

Санхүүгийн данс: Монгол Улсаас бусад гадаад улсад хийсэн хөрөнгө оруулалт/актив/, бусад улсаас Монгол Улсад хийсэн хөрөнгө оруулалтын/пассив/ гүйлгээг бүртгэдэг бүх данс хамаарна. Санхүүгийн дансанд активын өсөлт пассивынхаас илүү, активын бууралт пассивынхаас бага эсвэл актив өсөж, пассив буурсан үед "+" буюу алдагдалтайг, эсрэгээр пассивын өсөлт активынхаас илүү, активын бууралт пассивынхаас илүү эсвэл актив буурч, пассив өссөн үед "-" буюу ашигтайг илэрхийлнэ.

Цэвэр нөөц: Гадаад валютын улсын нөөцийг Олон Улсын Валютын Сангийн зээлийн үлдэгдэл болон богино хугацаат гадаад пассивын дүнгээр цэвэрлэж тооцсон нөөцийг ойлгоно.

Шууд хөрөнгө оруулалт: Харьяат бус нь нэг ба түүнээс дээш жилийн хугацаанд үйл ажиллагааны удирдлагад нөлөөлөхүйц саналын эрх бүхий хэмжээний хөрөнгийг харьяат аж ахуйн нэгжид нийлүүлэх, салбар, харьяа нэгжийг байгуулах үйл ажиллагааг ойлгоно.



Эх үүсвэр:

Монголбанк

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 6 дугаар сарын 12

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329272

Эдийн засгийн статистикийн албаны
статистикч Н.Адъяадорж
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212